



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Хамтын хаалттай сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 7.3 хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 /тавин сая/ ширхэг нэгж эрхтэй “Үндэсний хувьчлалын сан” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэгж эрхээс 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,500,000 /хоёр сая таван зуун мянга/ ширхэг нэгж эрхийг үүсгэн байгуулагч “Ард менежмент ҮЦК” ХХК-ийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх тухай энэ тогтоол гарсан өдрөөс хойш 6 сарын дотор олон нийтэд танилцуулж, сангийн дүрэмд заасан мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй нөхцөлд сангийн үүсгэн байгуулах ажиллагааг зогсоож, татан буулгах ажиллагааг зохион байгуулахыг “Ард менежмент ҮЦК” ХХК /Ч.Хандаа/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын 1-д заасан нийтэд санал болгон худалдаалах нэгж эрхийг 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалж, анхдагч зах зээлд худалдсан тайланг Хороонд ирүүлсэн нөхцөлд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Хороо шийдвэрлэхийг “Ард менежмент ҮЦК” ХХК /Ч.Хандаа/-д мэдэгдсүгэй.

5. Энэхүү тогтоолын 1-д заасан хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ард менежмент ҮЦК” ХХК /Ч.Хандаа/-д үүрэг болгосугай:

1/ Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг нийтэд санал болгох ажиллагааг гүйцэтгэхдээ нэгж эрхийн танилцуулгыг сонирхогч этгээд үнэ төлбөргүйгээр танилцах боломжийг бүрдүүлж ажиллах;

2/ Нэгж эрхийг худалдан авч буй хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын бодит эрсдэл, өгөөжийн талаарх мэдээллийг хүргэж, хөрөнгө оруулалтын болон ногдол ашгийн бодлогыг танилцуулж ажиллах;

3/ Сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд төлбөрийг дараа хийх нөхцлөөр худалдах, эсхүл төлбөргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглож, мөнгөн төлбөр хийгдсэний дараа нэгж эрхийг шилжүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллах;

4/ Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг энэхүү тогтоолын 3-д заасан хугацаанд гүйцэтгэж, анхдагч зах зээлийн тайланг Хороонд ирүүлэх;

5/ Анхдагч зах зээлд нэгж эрхээ худалдах ажиллагааг Хорооноос амжилттайд тооцож, тусгай зөвшөөрөл олгох хүртэлх хугацаанд хөрөнгө оруулагчдаас нэгж эрх худалдан авахаар төлсөн мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтын менежментийн компанийн данснаас тусдаа дансанд байршуулан тусгаарлах.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН